



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 13 өдөр

Дугаар А/305

Номгон

Биеийн тамир спортын газарт газар
эзэмшүүлэх тухай


“Газрын тухай хууль”-ийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1.1, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 13 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянхонгор сумын Рашаант 10 дугаар баг, Рашаант-3 гудамж, 319 тоот хаягт байрлах 4001 м² /0.4 га/ газрыг сагсан бөмбөгийн талбайн зориулалтаар аймгийн “Биеийн тамир спортын газар”-т /9007822/ эзэмшүүлсүгэй.

2.Эзэмшил газрыг улсын бүртгэлд бүртгэн гэрчилгээ олгож, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэн ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга /Д.Алтангэрэл/-т, эзэмшил газарт Улсын бүртгэлийн “Э” дугаар олгохыг Улсын бүртгэлийн хэлтсийн дарга /Ц.Мөнхжаргал/-т үүрэг болгосугай.

3.Эзэмшил газрыг зориулалтын дагуу зүй зохистой эзэмшихийг газар эзэмшигчдэд үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, уул уурхай, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч /Г.Энхбаяр/, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Д.Алтангэрэл/ нарт тус тус даалгасугай.



ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

681019779